



# МОНГОЛЫН ЛИБЕРАЛ НАМ

2004 оны 4-р сарын 05-ны өдөр

№ 09

Улаанбаатар хот

## МЛН-ын Удирдах Зөвлөлийн Хурлын Тогтоол

### УИХ-ын Сонгуульд бие даан оролцох тухай

Монголын Либерал Намын Удирдах Зөвлөлийн 2004 оны 03-р сарын 22-ны өдрийн хурлын шийдвэр, Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн хуулийн 19-р зүйлийн 1 дэхь заалтыг үндэслэн Тогтоох нь:

1. Монголын Либерал Нам 2004 оны УИХ-ын Сонгуульд “дангаараа” оролцохоор шийдвэрлэсүгэй.

2. УИХ-ын Сонгуулийн хуулийн дагуу холбогдох материарыг бүрдүүлж, Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий Хороонд бүртгүүлэхийг Намын Дарга Д.Банзрагч, Ерөнхий Нарийн Бичгийн Дарга Л. Алтанчимэг нарт даалгасугай.

MONGOLIAN  
LIBERAL PARTY

МОНГОЛЫН  
ЛИБЕРАЛ НАМ

МЛН-ын Намын Дарга ..... Д. Банзрагч

Улаанбаатар эрдэм Оюу Дээд сургууль  
Чингэлтэй дүүрэг 4-р хороо  
Улаанбаатар,  
Монгол улс

Утас/факс: +976-11-328198  
Утас/факс: +976-11-319039  
Мэйл: [newliberal@itie.mng.net](mailto:newliberal@itie.mng.net)  
[secretary\\_liberal@yahoo.com](mailto:secretary_liberal@yahoo.com)

УЛС ТӨРИЙН НАМХУУЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

4 дүгээр зүйл. Намын үйл ажиллагааны үндсэн зарчим

Нам үйл ажиллагаандаа дор дурдсан үндсэн зарчмыг баримтлана.

а) Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг дээдэлж сахин биелүүлдэг;

б) эх орон, ард түмний нийтлэг эрх ашгийг нийцүүлэн үйл ажиллагаа ил тод явуулах;

в) бусад намид нэр төрийг хүндэтгэх, дотоод хэрэгт нь хөндлөнгөөс үл оролцох, тэдгээрт өөрийн үзэл болшиг тунгшлал шаардахгүй байх;

г) өөрийн мөрийн хөтөлбөрөө нарийн чанар сахин мөрдөх;

д) хүмүүндэт, ардчилсан энэрэнгүй ёсыг эрхэмлэн дээдлэх;

е) Монгол улсадас бусад оронтой тогтоосон найрамдал, хиллэн ажиллагааг эрхэмлэн хүндэтгэх

Монгол Улсын Дээд шүүхийн 2004 оны 4 р сарын 05 ны өдрийн 1 р тогтоолоор


МОНГОЛЫН ИРГЭНИЙ АРДЧИЛСАН ШИЗЭ ДИВЕРИАЛ  
НАМЫН НЭРИЙГ МОНГОЛЫН ЛИБЕРАЛ  
НАМ ТЭЖ ӨӨРЧДӨН

НАМЫГ УЛСЫН БҮРТГЭЛЭН БҮРТГЭВ.



Р.ЖАМБАНЧОЙЖИЛ  
Н.ТӨРБАТ  
Д.ТУНГАЛАГ

Удирдах Зөвлөлийн 2004 оны 4-р сарын 05-өдрийн хурлаар хэлэлцэж батлав.



## МОНГОЛЫН ЛИБЕРАЛ НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

МОНГОЛЫН  
УИХ-ЫН СОНГУУЛЬ - 2004 он

Сонгуулийн уриа: Монголын дундчууд – Монголын хөгжил дэвшил

Мөрийн хөтөлбөрийн хураангуй :

“Иргэнээ дээдлэсэн төрийн тогтолцоо  
Ирээдүйгээ харсан хөгжлийн бодлого  
Хүнээ эрхэмлэсэн нийгмийн халамж  
Хэрэглэгчээ дээдлэсэн зах зээлийн харилцаа  
Энх амгаланг хичээсэн эе эв ”-ийн төлөө.

Мөрийн хөтөлбөрийн агуулга:

### 1. Иргэнээ дээдлэсэн төрийн тогтолцооны төлөө

1.1. Нам биш, төр биш, харин иргэн төвтэй төрийн тогтолцоог төлөвшүүлэхийг зорино.

Үүний тулд:

- Төр, түүний бүх шатны байгууллагууд, түшмэдүүдийн хүнд суртлыг багасгаж, иргэддээ үйлчилдэг, тайлагнадаг, иргэдийн зүгээс хянагддаг, хариуцлага тооцогддог тогтолцоо, хууль эрх зүйн механизмыг бүрдүүлэх
- Намуудыг том, жижиг гэж ялгаварлахгүйгээр олон намын тогтолцоог хөгжүүлж, олон урьгалч үзэл бодлыг уралдуулан улс төрийн хүрээнд эрүүл саруул, шударга өрсөлдөөн бий болгох бодлогыг хэрэгжүүлэх
- Сонгуулийн тогтолцоог холимог хэлбэрт шилжүүлж, сонгогчдын саналын парламент дахь тэгш төлөөллийг хангах
- Төрийн бус байгууллагуудыг дэмжин хөгжүүлж, тэдэнд төрийн ачааллыг тэнцүү үүрүүлэх
- Төрийн мэргэшсэн албан хаагчдыг намын харъяаллаас ангид байлгаж, нийгмийн батлагааг хангах
- Авилгалын аливаа илрэлтэй тууштай тэмцэж, хуулийн өмнө тэгш байх, хуулийг дээдлэн хэрэгжүүлэх
- Төрийн удирдлагын төвлөрлийг сааруулах

1.2. Төрийн бодлогот сонгогч олон түмний саналыг өргөн тусгахын төлөө ажиллана.

Үүний тулд:

- Төр, олон түмний хоорондын зайг ойртуулах бүхий л арга хэрэгслүүдийг өргөн ашиглах
- Хэвлэл, мэдээллийн хэрэгслийн эрх чөлөөг дээдлэх
- Төр, олон түмний харилцаанд мэдээллийн технологийн ололтыг өргөн ашиглах Тухайлбал, “Нээлттэй засаглал” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Е-ЗАСАГЛАЛ” улмаар “Е-АРДЧИЛАЛ” төслүүдийг хэрэгжүүлэх
- Төр, засгийн үйл ажиллагааны бүх түвшинд нам-улс төрийн хүчин, сонгогч- олон түмэн, хэвлэл, мэдээллийн хэрэгслийн оролцоог өргөтгөн, хяналт тавих, хариуцлага тооцох механизмыг бий болгох.

1.3. Хууль эрх зүйн тогтолцоог улам төгөлдөржүүлнэ.

Үүний тулд :

- Нийгмийн харилцааны тулгамдсан асуудлуудыг зохицуулах хууль тогтоомжуудыг эхний ээлжинд боловсруулан сахих, тухайлбал:
  - Байгалийн тэнцвэрийг хадгалах багц хууль
  - Цөлжилтийг сааруулах хууль
  - Хүнсний аюулгүй байдлыг хамгаалах хууль
  - Мэдээллийн нөөцийг зохистой ашиглах хууль
  - Хүний хөдөлмөрийн үнэлэмжийн тухай хууль гэх зэрэг хуулиудыг боловсруулж хэрэгжүүлэх
- 1.4. Одоо мөрдөгдөж байгаа хууль тогтоомжууд , тухайлбал, үндсэн хуулийг эргэж харах
- 1.5. Хууль эрх зүйн тогтолцооны үзэл баримтлалыг ард иргэдийн, түүний дотор дундчуудын эрх ашигт нийцүүлэх хандлагаар шинэчлэн өөрчлөх.

## **2. Ирээдүйгээ харсан хөгжлийн бодлогын төлөө**

- 2.1. Монгол улсын тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн биелэлтийг Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа буюу дөрөв, дөрвөн жилээр гаргаж, ард түмэндээ тайлагнан, Засгийн газруудын үйл ажиллагааг дүгнэдэг механизмыг хуульчилах
- 2.2. Монгол улсын 21-р зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөртэй бусад бүх хөтөлбөрүүдийг уялдуулан зангидаж , биелэлтийг хянадаг бүтцийг бий болгох
- 2.3. Хөгжилд чиглэсэн бүтээн байгуулалт, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэх

Үүний тулд:

- Эдийн засгийн чөлөөт бүсүүдийг бий болгож, хөгжүүлэх
  - Ажилгүйдлийн түвшинг 4 хувиас хэтрэхгүй байхаар ажлын байрыг нэмэгдүүлэх
  - Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж, жилийн дундаж өсөлт 5 хувиас багагүй байх макроэдийн засгийн бодлого баримтлах
  - Эдийн засгийн либералчлалыг өргөжүүлэх
- 2.4. Байгаль орчинд сөрөг нөлөөгүй үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжин хөгжүүлэх
- 2.5. Экологийн цэвэр бүтээгдэхүүнээр ард иргэдээ хангаад зогсохгүй экспортлохыг дэмжих
- 2.6. Мэдээлэлжсэн нийгэм байгуулах стратеги баримтлах.

Үүний тулд :

- Мэдээлэл, холбооны технологийн хөгжлийг тэргүүлэх чиглэл байлгахын хамт дэд бүтэц / эрчим хүч, зам тээвэр,нийтийн аж ахуй /-ийн хүртээмжийг нэмэгдүүлэн хөдөлгөөнт холбооны ирээдүйтэй технологиудыг нутагшуулан хөгжүүлэх
  - Бүх нийтийн боловсрол, түүний дотор мэдээллийн технологийн боловсролыг дээшлүүлэхийн тулд зайн сургалтын хүрээг өргөжүүлэх
- 2.7. Мэдээлэл, мэдлэгийг тэргүүлэх нөөц болгох бодлого баримталж, оюуны хөдөлмөрийн үнэлэмж, шинжлэх ухааны ололтын практик хэрэглээг дээшлүүлэх
- 2.8. Хөгжлийн бодлого, загварыг боловсруулан хэрэгжүүлэхэд их дээд сургууль,эрдэм шинжилгээний байгуулага, эрдэмтдийн оролцоог нэмэгдүүлэх
- 2.9. Байгал орчинд аюулгүй үйлдвэрлэлийн технологийг дэмжин хөгжүүлэх

Үүний тулд:

- Байгалийн унаган төрхийг хадгалан хамгаалах, нөхөн сэргээх
- Байгалийн хязгаарлагдмал нөөцийг зохистой ашиглах хууль эрх зүй, зан заншил, уламжлалт ёс, нийгмийн сэтгэл зүйн орчныг бүрдүүлэх
- Материаллаг орц багатай, оюуны багтаамж ихтэй, экспортод чиглэсэн болон импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бүх талаар дэмжих

- 2.10. Эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлал, мэдээллийн технологи-оюуны үйлдвэрлэлийг эдийн засгийн тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх
- 2.11. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг түлхүү ашиглах, тухайлбал, нар, салхи, усан цахилгаан станцуудыг барих замаар эрчим хүчний хэрэгцээг хангах
- 2.12. Зам тээврийн сүлжээний хөгжлийг эрчимжүүлэх

Үүний тулд:

- Мянганы замын бүтээн байгуулалтыг дэмжин үргэлжлүүлэх
  - Дотоодын болон олон улсын агаарын тээврийн сүлжээг өргөтгөх
  - Агаарын орон зайн ашиглалтыг сайжруулах
  - Төмөр замын улс хоорондын ачаа, зорчич тээврийг нэмэгдүүлэх
  - Бүсийн төвүүд ба харъяа аймгууд хоорондын шууд тээврийг зохион байгуулж эхлэх
- 2.13. Бүс нутгийн хөгжлийн санг бүс тус бүрээр байгуулж, орон нутгийн бие даасан хөгжлийг хангах
  - 2.14. Хөдөө орон нутагт малын тэжээлийн жижиг дунд үйлдвэр байгуулах бодлогыг хэрэгжүүлэх

### **3. Хүнээ эрхэмлэсэн нийгмийн халамжийн төлөө**

- 3.1. Хүн амын дундач давхрагат түшиглэсэн хийгээд цөөнхи нь хэт баяжих, олонхи нь хэт ядуурхаас хамгаалсан нийгэм-эдийн засгийн бодлого баримтлах
- 3.2. Амьжиргааны баталгаажих доот түвшинг хотод 100000 төгрөг, хөдөөд 70000 төгрөг болгох
- 3.3. Орон сууцны нөхцөл, хангамжийг сайжруулахын тулд 30-аас доошгүй жилийн хугацаатай, жилд 5-аас илүүгүй хүүтэй зээл олгох "орон сууцны зээлийн тусгайлсан бодлого" хэрэгжүүлэх
- 3.4. Бүх нийтээр бүрэн бус дундаас доошгүй боловсролтой байх зорилтыг дэвшүүлэн ажиллах
- 3.5. Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгож, эрүүл мэндээ хамгаалах хөшүүрэг болгохуйц хэлбэрт шилжүүлэх. Тухайлбал, архи, тамхи хэрэглэдэггүй болон биёнтамираар байнга хичээлэлдэг хүнд урамшил олгох, хөнгөлөлт үзүүлэх, тодорхой хугацаанд эмнэлэгийн үйлчилгээ аваагүй хүнийг эрүүл мэндийн даатгалаас чөлөөлөх, амралт, сувилал, аялал жуулчлалд үнэ төлбөргүй явуулах гэх мэт.
- 3.6. Тэтгэвэр, тэтгэмжийн доод хэмжээг хотод 100000төгрөг, хөдөөд 70000 төгрөгт хүргэх
- 3.7. Тэтгэвэрт шинээр гарах хүмүүст ажилласан хугацаатай нь дүйцүүлэн нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгох
- 3.8. Эх нялхас, өвгөд хөгшдид,бага насны хүүхдийн нэгдсэн халамж – хөдөлмөрийн газрууд / өдрийн цагаар ажиллах / байгуулж ажиллуулахад төр засаг, бизнесийн байгууллагуудын анхаарлыг хандуулах замаар "траншөйнд амьдрах үзэгдэл" –ийг халах
- 3.9. Ажилгүйдлийн даатгалын сангийн үлдэгдэл нөөцийг ажлын байр шинээр бий болгоход зориулах
- 3.10. Боловсрол, эрүүл мэнд болон бусад салбарт одоогийн мөрдөгдөж байгаа бусад хөнгөлөлтүүдийг боловсронгуй болгон мөрдөх

### **4. Хэрэглэгчээ дээдэлсэн зах зээлийн харилцааны төлөө**

- 4.1. Бизнесийн хүрээний удирдлагат хэрэглэгч, үйлчлүүлэгчээ дээдлэсэн зарчим буюу маркетингийн удирдлагын зарчмыг тууштай баримтлах
- 4.2. Бизнесийн бодлого нь "дундчуудад" түшиглэсэн байх
- 4.3. Ажиллагчдын хөдөлмөрийг хэт мөлжихийн эсрэг тууштай тэмцэх
- 4.4. Хууль бус бизнесийг бүх хүрээнд хязгаарлах

- 4.5. Хүүхэд , эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг зохистой норм хэмжээнд байлгах
- 4.6. Олон хүүхэдтэй болон өрх толгойлсон эмэгтэйчүүдийн цалин хөлс,тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх
- 4.7. Жил бүр 15000 мянган өрхөд автомашин, 10000 өрхөд жижиг, дунд үйлдвэрийн тоног төхөөрөмж лизингээр олгох замаар амьжиргааны баталгааг хангаж, ажлын байрыг нэмэгдүүлэх
- 4.8. Хувь хүмүүс, аж ахуйн нэгжийн зээллэгийн даатгалын тогтолцоог бий болгох
- 4.9. Өрхийн төсвийн зардал, тухайлбал, ус, цахилгаан, дулааны зардлыг хэмнэх арга хэрэгсэл, эдийн засгийн тооцоо, бизнес эрхлэх арга ухааныг хүүхдэд бага наснаас нь эзэмшүүлж хэвшүүлэх бодлогыг сургалтаар дамжуулж хэрэгжүүлэх
- 4.10. Хэрэглэгчдэд бизнесийн зөвлөх болон сургах үйлчилгээ үзүүлдэг төвүүдийн сүлжээг бий болгох

## **5. Энх амгаланг хичээсэн эв эвийн төлөө**

5.1. Дотооддоо эв эвээ сахиж, улс төрийн тогтвортой байдлыг хангана.

Үүний тулд:

- Сонгогчдын саналын тэгш төлөөллийг хангасан Парламент болон Эвслийн Засгийн газрын ажиллах хууль эрх зүйн очныг бүрдүүлэх
- Аливаа хямралт байдлаас сэргийлэх
- Улс төрийн хүчнүүдийн харилцаанд харилцан хүндэтгэл, зөвшилцлийн зарчмыг хэвшил болгох
- Олон намын тогтолцоог хүлээн зөвшөөрч, боловсронгуй болгох чиглэлээр Улс төрийн намуудын тухай хуулийг шинэчлэх
- Улс төрийн өрсөлдөөнийг эх орон ,ард түмний эрх ашгийн төлөө шударга, ил тод , хуулийн хүрээнд явуулдаг механизмыг бүрдүүлэх
- Цөөнхийн эрх ашгийг хүндэтгэх үндсэн дээр олонхи нь шийдвэр гаргадаг зарчмыг мөрдөх , цөөнхийн санал бодлыг сонсдог байх
- Төрийн өндөрлөгүүд ,улс төрийн хүчнүүд , ТББ-ын уулзалт ярилцлагыг тогтмолжуулах , ард түмэнд ил тод байлгах
- Өрөөсгөл сурталчилгаа хийх, хэн нэгнээ гүтгэн муучлахын эсрэг тууштай зогсож, ард нийтийн эрх ашигт нийцсэн санал бодлуудыг ил тод тугаан хэлэлцэх

5.2. Гадаадад улс орны нэр хүндийг өргөхийн төлөө тууштай ажиллана.

Үүний тулд :

- Хүн төрөлхтний нийтлэг эрх ашгийг эн тэргүүнд тавих
- Хүн төрөлхтний сайн сайхны тусын тулд Монголын ард түмний оруулах хувь нэмрийн үнэ цэнийг өргөх
- Хүн төрөлхтний бүтээсэн үнэ цэнэтэй, дэвшилттэй зүйлийг хайрлан хамгаалах
- Монголын ард түмний хөгжил дэвшилд эерэг нөлөөтэй ололтуудыг нутагшуулан хөгжүүлэх
- Дэлхийн улс орнуудтай эв найртай, энх амгалан оршин тогтнох.

Мерийн хөтөлбөрийг боловсруулсан дэд дарга О.Балдангомбо